



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Аудитын сэдэв: “Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, тогтолцооны үр нөлөө”

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх: Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу гүйцэтгэв.

**ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН АСУУДЛЫГ
ЗОХИЦУУЛЖ БУЙ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН БҮРДСЭН Ч
ХЭРЭГЖИЛТИЙГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.**

Аудитын тайланг хүргүүлсэн: Дархан-Уул аймгийн ИТХ, Засаг дарга, Төрийн албаны зөвлөлийн Дархан-Уул аймаг дахь салбар зөвлөл

ДАРХАН-УУЛ АЙМАГ

2024 оны 11 дүгээр сар

Аудитын зорилго, зорилтууд:

“Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, тогтолцооны үр нөлөө”-т байдалд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- *Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, хууль эрх зүйг хэрэгжүүлэх тогтолцоо бүрдсэн эсэх;*
- *Төрийн байгууллагуудын хүний нөөцийн тогтолцоо нь сайн засаглалыг бий болгож байгаа эсэх;*

Аудитын хамарсан хүрээ:

Аудитад орон нутгийн төсөвт байгууллага 6, СӨБ 12, ЕБС 6, Соёлын байгууллага 3, ЭМБ 4, улсын төсвийн байгууллага 13, нийт 43 байгууллагын 2012-2024 оны байгууллагын бүтэц орон тоо, зохион байгуулалт, чиг үүрэг, хүний нөөцийн бодлого, тогтоол, шийдвэрүүд, үйл ажиллагааны болон санхүүгийн баримт материал, хурлын тэмдэглэл, холбогдох бусад материал болон ҮАГ-ын ГНАГ-ын нэгдсэн судалгаанд орон нутгийн болон улсын төсвийн 125 байгууллагыг хамруулав.

БҮЛЭГ 1. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН ТАЛААРХ ХУУЛЬ, ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

1.1.2 Дархан-Уул аймаг болон төрийн зарим байгууллагууд стратеги төлөвлөгөөг баталж хэрэгжүүлээгүй байна

Аймгийн холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтнууд 2019 оноос хэрэгжиж эхэлсэн Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын 53 дугаар зүйлийн 53.1¹, Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор баталсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”-ын 2.1², 2.2³-д заасан аймгийн стратеги төлөвлөгөөг боловсруулж, батлаагүй байна.

Стратеги төлөвлөгөө батлаагүй байгууллагын тоо сүүлийн 4 жилд өмнөх жилүүдийн дунджаас 22 хувиар буурсан боловч нийт байгууллагын тоонд эзлэх хувь 41.6 хувьтай байгаа нь хангалтгүй байна.

1.1.2 Аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын 85.7 хувь нь стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнаагүй, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгээгүй байна.

Аудитаар аймгийн ТЕЗ-ийн харьяаны стратеги төлөвлөгөө баталсан 7 байгууллагын хэрэгжилтийг шалгахад аймгийн Захирагчийн ажлын албанаас бусад байгууллага стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнаагүй, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгээгүй байна. Энэ нь стратеги төлөвлөгөөг байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэхээр журам, аргачлалд заасан байхад төрийн байгууллагууд зөвхөн нэг жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд анхаарч, стратегийн төлөвлөгөөний биелэлтийг үнэлээгүй байна.

¹ “Төсвийн ерөнхийлөн захирагч хууль тогтоомжид нийцүүлэн харьяа байгууллагын дөрвөн жилийн стратеги төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг хариуцан зохион байгуулна.”

² “Стратеги төлөвлөгөө нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө болон аймаг, нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд туссан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэх бөгөөд арга хэмжээний төлөвлөгөө батлагдсанаас хойш хоёр сарын дотор салбарын, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн, байгууллагын стратеги төлөвлөгөөг тус тус дөрвөн жилийн хугацаатайгаар боловсруулна.”

³ “Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, яам нь тухайн сайдын эрхлэх асуудлын хүрээний стратеги төлөвлөгөөг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар нь тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн стратеги төлөвлөгөөг дөрвөн жилийн хугацаатайгаар боловсруулан төсвийн ерөнхийлөн захирагчаар батлуулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна”

1.1.3 Аймгийн ЗДҮАХ-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд хүний нөөцийн бодлогын чиглэлээр тусгасан арга хэмжээ нэмэгдэж, хэрэгжилтийн хувь өссөн ч төрийн байгууллагуудын бүх талын оролцоо хангалтгүй байна.

Дархан-Уул аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд хүний нөөцийн бодлогын чиглэлээр 2013-2016 онд 3 зорилт, 9 арга хэмжээ, 2017-2020 онд 8 зорилт, 9 арга хэмжээ, 2021-2024 онд 6 зорилт 18 арга хэмжээ, 2021-2024 онд 6 зорилт, 18 арга хэмжээг төлөвлөжээ.

Аймгийн ЗДҮАХ-ийг хэрэгжүүлэх 2012-2024 оны арга хэмжээний төлөвлөгөөнд хүний нөөцийн бодлогын талаар авч хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ нэмэгдэж, хэрэгжилтийн дундаж хувь өссөн боловч орон нутгийн 7 байгууллага одоог хүртэл “Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр”-ийг батлаагүйгээс зарим арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байна.

1.1.4 Төрийн албаны салбар зөвлөлөөс төрийн байгууллагуудын хүний нөөцийн бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж байгаа хэдий ч зөрчлүүд давтагдсаар байна.

Аудитаар төрийн албаны салбар зөвлөлийн 2013-2023 оны үйл ажиллагааны тайлан, явуулсан бичгээс хүний нөөцийн бодлогын хэрэгжилтэд хяналт, шалгалт болон байгууллагуудад хүргүүлсэн зөвлөмжийн баримт бичигт дүн шинжилгээ хийхэд 2013-2021 оны хүртэл төрийн албаны зөвлөлийн баталсан удирдамжийн дагуу шалгалт хийгээгүй байна.

Харин Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга 2019 оноос хэрэгжиж эхэлснээс хойш 2022, 2023 онд аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний төрийн байгууллагуудад хяналт шалгалт хийж, зөвлөмж хүргүүлжээ.

Аудитаар салбар зөвлөлөөс гаргасан зөвлөмжийн чиглэлд дүн шинжилгээ хийхэд Төрийн албаны тухай хуулийн зөрчил багасаж байгаа боловч “албан тушаалын тодорхойлолтод заасан ерөнхий болон тусгай шалгалт өгөөгүй иргэдийг томилсон”, “сул орон тооны захиалгыг хуульд заасан хугацаанд ирүүлээгүй”, “Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах орчин, нийгмийн баталгаа”-ны хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлээгүй, “ХНУМТ” цахим системийг бүрэн ашиглаагүй” зэрэг зөрчлүүд дахин давтагдсаар байна. Салбар зөвлөлөөс хэрэгжүүлэх чиг үүргийн хүрээнд зөвлөмж өгөх, чиглүүлэх, арга зүйн дэмжлэг үзүүлэх, аймгийн Засаг даргатай байгуулах төрийн байгууллагуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд санал хүргүүлэх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн ч үр дүн хангалтгүй байна.

1.2.1 Орон нутагт зарим нарийн мэргэжлийн боловсон хүчин хүрэлцээгүй хангалтгүйгээс сул орон тоо нхөгдөхгүй байна.

Аймгийн хэмжээнд төрийн албаны нөөцөд 170 иргэн бүртгэлтэй байгаа боловч чухал шаардлагатай нарийн мэргэжлийн хүний нөөц хүрэлцээгүй, дутагдалтай байгаагаас төрийн захиргааны удирдах албан тушаалд 3, гүйцэтгэх албан тушаалд 49, нийт 52 сул орон тоо нөхөгдөөгүй байна.

Мөн аймгийн ЗДТГ-т Засгийн газрын 2023 оны 312 дугаар тогтоолоор баталсан “Тогтвортой амьжиргаа-3” төслийн хугацаа дуусаж байгаатай холбоотойгоор “Орон нутгийн хөгжлийн сан” хариуцсан мэргэжилтний орон тоог нэмж баталсан байхад албан тушаалын тодорхойлолт батлагдаагүй шалтгаанаар одоог хүртэл сул орон тоог зарлаагүй, Хонгор, Шарын гол сумдын соёлын төвийн музейн ажилтнаар мэргэжлийн бус иргэдийг томилсон, нэгдсэн эмнэлэгт зүрх судас, эрүү нүүр судлал, элэг цөс, нойр булчирхайн нарийн мэргэжлийн эмч нар дутагдалтай зэргээс шалтгаалж хүний нөөц нөхөгдөөгүй байна.

Дээрх хүний нөөцийн дутагдал нь малын их эмчийг бэлтгэх ХААИС-ийн элсэлт, төгсөлт жилээс жилд 30 хувиар буурсан, сумдад ажиллах мэргэжлийн хүний нөөц дутмаг,

насжилт залуужснаас жирэмсэн, амаржих, хүүхэд асрах чөлөө авах, шилжилт хөдөлгөөн ихэссэн зэргээс шалтгаалжээ.

1.2.2 Иргэдэд төрийн үйлчилгээг цахим хуудсаараа дамжуулан нээлттэй мэдээлж байна.

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль болон бусад холбогдох дүрэм журамд заасны дагуу төрийн үйлчилгээг цахим хуудсаараа дамжуулан иргэдэд хүргэж байгаа эсэхийг шалгахад төрийн байгууллагууд мэдээллийг хүртээмжтэй ил тод нээлттэй мэдээлж байна.

Гэхдээ цахим хуудсанд шаардлагатай мэдээллийг оруулсан байдал, мэдээлэл оруулсан хугацаа, ашиглагчид зориулж боломжит хугацаанд нийтэлсэн байдал, мэдээллийг тогтмол шинэчилсэн байдлыг 4 асуулгаар шалгахад байгууллагууд цахим хуудсандаа мэдээллийн ил тод байдлыг хангахад чиглэсэн тусдаа цэстэй, мэдээллийн төрөл, ангилал бүрээр мэдээллээ оруулж байгаа ч хүний нөөцийн мэдээлэл, иргэдийг хэзээ хүлээн авах, уулзах цагийн хуваарь, албан хаагчийн ёс зүйн дүрэм, хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журам зэргийг цахим хуудсанд байрлуулаагүй, мэдээлэл оруулсан цаг хугацаа нь тодорхойгүй, мэдээллийн шинэчлэлийг тухай бүр хийгээгүй зэрэг зөрчлүүд нийтлэг байна.

1.3.1 Боловсролын салбарын зарим байгууллагууд албан тушаалын тодорхойлолт боловсруулах үлгэрчилсэн загварыг мөрдөж ажиллаагүй байна

Аудитаар түүвэрт хамрагдсан 37 байгууллагын 223 албан хаагчийн мэргэжил, мэргэшил, туршлага нь албан тушаалын тодорхойлолтод заасан шаардлага, шалгуурыг хангаж байгаа эсэхийг төрийн албан хаагчийн хувийн хэргийн бүрдлээс шалгахад, төрийн жинхэнэ алба хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг журмын дагуу боловсруулж, батлуулсан боловч Хонгор, Орхон сумдын Соёлын төвийн музейн ажилтан нь албан тушаалын тодорхойлолтод заасан мэргэжлийн шаардлага хангаагүй, “Түвшин холбоо” ӨЭМТ нь эмч, сувилагчийн албан тушаалын тодорхойлолтод боловсрол, мэргэжил, мэргэшил, туршлагын талаарх шаардлага, шалгуурыг заагаагүй, ЕБС, СӨБ-ийн байгууллагад ажиллаж байгаа эмч нарын албан тушаалын тодорхойлолтод мэргэжил, мэргэшил, туршлагыг харилцан адилгүй боловсруулсан зэрэг зөрчил байна.

Энэ нь томилох эрх бүхий этгээд буюу төсвийн шууд захирагч хяналт тавиагүй, албан тушаалын тодорхойлолт боловсруулсан албан хаагчид холбогдох заавар, аргачлалын талаар тодорхой мэдлэг, туршлага хангалтгүйгээс шалтгаалжээ.

1.3.2 Төрийн албан хаагчийг тогтвор суурьшилтай ажиллуулах, тэдний нийгмийн баталгааг хангах чиглэлээр аймаг орон нутгийн зүгээс тодорхой дэмжлэг үзүүлсэн байна

Түүвэрт хамрагдсан байгууллагуудад мөрддөг хууль, журам нийгмийн баталгаатай холбоотой онцлог заалтуудыг судалж үзэхэд салбар бүрийн хуульд нийгмийн баталгаа, тэтгэмж, урамшууллын хэмжээ харилцан адилгүй байна.

Мөн цалингийн нэмэгдэлд судалгаа хийхэд орон нутгийн төсөв бүрдүүлэлтээс шалтгаалж орон нутгийн нэмэгдлийг 20-100 хувиар тооцож олгожээ. Үндэсний статистикийн хорооноос гаргасан судалгаанаас харахад сүүлийн 10 жилд төрийн албан хаагчдын цалин 3.3 дахин нэмэгдсэн байна. Төрийн албан хаагчдын орон сууцны нөхцөлийг сайжруулахаас гадна Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлд заасан нийтлэг баталгааг хангах чиглэлээр тэдний ажиллах орчин нөхцөлийг сайжруулах, гадаад, дотоодын сургалтад хамрагдах зэрэгт дэмжлэг, туслалцаа үзүүлэх зэрэг 17 хөтөлбөрийг хэрэгжүүлжээ.

1.3.3 Төрийн байгууллагууд сул орон тоог хууль, журмын дагуу олон нийтэд ил тод мэдээлж, нөхөн томилжээ

Төрийн албаны зөвлөлийн Дархан-Уул аймаг дахь салбар зөвлөл Төрийн жинхэнэ болон төрийн үйлчилгээний удирдах албан тушаалын сул орон тоог хууль, журмын дагуу Төрийн албаны зөвлөлийн hh.csc.gov.mn болон Дархан-Уул аймгийн ЗДТГ-ын www.darkhan.gov.mn цахим хуудсаар олон нийтэд ил тод мэдээлсэн байна.

Төрийн албаны ерөнхий шалгалтад бүртгүүлсэн, тэнцэж нөөцөд бүртгэгдсэн иргэдийн тоог сүүлийн 5 жилээр авч үзэхэд амжилтын хувь дунджаар 26.9 хувьтай буюу хангалтгүй байгаач шалгалтад оролцох иргэдийн тоо 2019 оноос хойш тасралтгүй өссөн үзүүлэлттэй байна.

Үндэсний статистикийн хорооноос гаргасан судалгаагаар төрийн албаны ерөнхий шалгалтад бүртгүүлсэн иргэдийн тоо өсөж байгаа нь цалин хангамж өссөн, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бүрдсэн нь харагдаж байна.

1.3.4 Хууль, тогтоомжид орсон нэмэлт өөрчлөлтийн нөлөөгөөр шүүхэд гаргасан нэхэмжлэлийн тоо буурчээ

Шүүхийн байгууллагаас нийт 90 нэхэмжлэлийн 6.7 хувь буюу 6 нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон бол 2.2 хувь буюу 2 нэхэмжлэлийг зохигчдын эвлэрлийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгох шийдвэр гарч, 91.1 хувь буюу 82 нэхэмжлэлд төрийн албан хаагчийг албан тушаалд нь эгүүлэн томилж, ажилгүй байсан хугацааны цалин, НДШ-ийн нөхөн төлбөрт 220,729.6 мянган төгрөгийг нэхэмжлэгчид олгох шийдвэр гаргасан байна. Харин Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлд орсон нэмэлт өөрчлөлтөөр төрд учруулсан хохирлыг шийдвэр гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэхээр хуульчилснаар 2022 оноос хойш 5 нэхэмжлэлийн 29,177.5 мянган төгрөгийн цалинг нөхөн төлүүлж, албан тушаалд нь эгүүлэн томилуулах шийдвэр гарч буурсан үзүүлэлттэй байна.

Аудитаар шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй зөрчилд төсвийг хохиролгүй болгох төлбөрийн акт тогтоож, зөвлөмж хүргүүлсэн.

1.3.5 Төрийн албан хаагчийн нэгдсэн тоо бүртгэлийн мэдээллийн сангийн бүрдүүлэлт, ашиглалт хангалтгүй байна.

Засгийн газрын 2019 оны 74 дүгээр тогтоолоор баталсан журмын дагуу Төрийн албаны ХНУМТ-ийн цахим системд мэдээллээ байршуулдаг 37 байгууллагын алба хаагчдаас Random программ ашиглан 223 албан хаагчийн хувийн хэргийг Төрийн албаны ХНУМТ-ийн цахим системд оруулсан мэдээлэлтэй тулган шалгахад ур чадвар, мэргэшил, шагнал, шийтгэл, бусад мэдээлэл, бүтээл, цол, зэргийн мэдээллийг нь огт мэдээлээгүй нь 42-77 хувийг эзэлж байна.

Энэ нь төсвийн шууд захирагчийн хяналт сул, боловсон хүчний дутагдалтай байдал, ажлын хариуцлага алдагдсан зэрэг олон хүчин зүйл нөлөөлсөн байна.

Тухайлбал түүвэрт хамрагдсан байгууллагууд хүний нөөц хариуцсан ажилтны орон тоо батлагдаагүйгээс хавсран гүйцэтгүүлдэг, мөн ХНУМТ-ийн цахим системд мэдээлэл оруулах ажилтан солигдсон зэргээс шалтгаалж мэдээлэл дутуу орох, орхигдох асуудал гардаг байна.

1.3.6 Төрийн албаны ХНУМТ-ийн цахим системд Төрийн албаны салбар зөвлөлөөс хяналт шалгалт хийж байгаа ч үр дүн хангалтгүй байна

Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн даргын тушаалаар баталсан ажлын хэсэг, удирдамжийн дагуу Төрийн албаны зөвлөлийн Дархан-Уул аймаг дахь салбар зөвлөлөөс Төрийн албаны ХНУМТ-ийн цахим системийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчилд хугацаатай үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг хангуулж ажилласан байна. Тухайлбал 2023 онд 20, 2024 онд 24 байгууллагын 600 гаран албан хаагчдын хувийн хэрэг, Төрийн албаны ХНУМТ-ийн цахим системийн бүрдүүлэлтэд үзлэг шалгалт хийжээ. Гэвч Төрийн албаны салбар зөвлөлөөс тавих хяналт үр дүн багатай байна. Тодруулбал түүвэрт хамрагдсан 37 байгууллагын Төрийн албаны ХНУМТ-ийн цахим системийн бүрдүүлэлтийг шалгахад 8.1 хувь буюу 3 байгууллага мэдээллээ бүрэн оруулсан байлаа.

БҮЛЭГ 2. ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН УР ЧАДВАРЫГ ХӨГЖҮҮЛЖ, ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ЦАХИМЖУУЛСНААР ИРГЭДИЙН ЦАГ ЗАВЫГ ХЭМНЭЖ БАЙНА.

2.1.1 Төрийн албан хаагчид орон зайнаас үл хамааран цахим хэлбэрээр мэргэшүүлэх сургалтад хамрагдаж байна.

Төрийн албаны тухай хуулийн 24 дүгээр зүйл, Засгийн газрын 2019 оны 299 дүгээр тогтоолын төрийн жинхэнэ албан хаагчийг мэргэшүүлэх багц сургалтыг Удирдлагын академи хариуцан зохион байгуулж байна.

Мэргэшүүлэх сургалтаар төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтын агуулга, хөтөлбөрийн хүрээнд төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх богино хугацааны сургалтад, төрийн захиргааны албан хаагчдыг тэргүүн, эрхэлсэн болон ахлах түшмэлийн ангиллаар сургалтад хамруулж байна.

Дархан-Уул аймгийн хэмжээнд 2019-2023 онд төрийн жинхэнэ албан хаагчдыг чиглүүлэх богино хугацааны болон дунд хугацааны сургалтад нийт 181 албан хаагч, 2013-2023 онд сургалтын байгууллагад 1, 5, 10 дахь жилдээ ажиллаж буй СӨБ, ЕБС-ийн багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтад нийт 1,030 багш нарыг цахим болон танхимын хэлбэрээр хамруулсан байна.

2.1.2 Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр байгууллагад шилжүүлэн томилоход тусгай шаардлагад нийцсэн эсэхийг хянах, дүгнэлт гаргах эрхзүйн зохицуулалтгүй байна.

Аудитаар төрийн захиргааны байгууллагаас шилжүүлэн томилсон 11 албан хаагчийн хувийн хэргийг шалгахад 2017-2021 онд 3 албан хаагчийг өөр байгууллагаас шилжүүлэх тушаал гаргахдаа албан тушаалын ангилал дэвшүүлсэн, өмнөх ажлаас чөлөөлсөн нөөцөөс хасагдсан албан хаагчийг томилсон зөрчил илэрлээ.

Энэ нь Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны 34/31 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам”-ын 1.5-д “Төрийн жинхэнэ албан хаагчийг адил төрлийн албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулна”, 5.1-т “Төрийн жинхэнэ албан хаагч тухайн албан тушаалын тусгай шаардлагыг хангаж буй тохиолдолд адил төрлийн албан тушаалын адил ангилалд шилжүүлэн ажиллуулахдаа тусгай шалгалтгүйгээр шууд томилно” заасантай тус тус нийцэхгүй байна.

Дээрх зөрчлөөс харахад Төрийн жинхэнэ албан хаагчийг төрийн байгууллага хооронд шилжүүлэн томилоход албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагад нийцсэн эсэхийг хянах, дүгнэлт гаргах эрх зүйн зохицуулалтгүй байна.

Өөрөөр хэлбэл Төрийн албаны зөвлөлөөр хянуулах эрх зүйн зохицуулалт байхгүйгээс төсвийн захирагчид албан тушаалын шаардлагад нийцэхгүй төрийн жинхэнэ албан хаагчдыг шилжүүлэн томилж байна.

2.1.3 Төрийн үйлчилгээг цахимжуулах үйлчилгээг үзүүлж буй “ХУРДАН” цэгийн 17 албан хаагч буюу 53.7 хувь нь E-Mongolia системийн сургалтад хамрагдаагүй байна.

Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын харьяа Дархан-Уул аймаг дахь төрийн цахим үйлчилгээний хэлтсийг 5 албан хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, 2023 оны 03 дугаар сард “Дархан зах”-ын нэг цэгийн үйлчилгээний төвд “Хурдан” цэгийн үйлчилгээг иргэдэд үзүүлж байна.

Тус хэлтсийн 2 албан хаагч Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газраас зохион байгуулсан сургалтад хамрагдан сургагч багшийн эрхийг авч, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын сургалт хөгжлийн хэлтсийн сургалтуудад хамрагдаж байна.

Аудитаар Дархан-Уул аймаг дахь төрийн цахим үйлчилгээний хэлтсийн албан хаагчид болон багийн төвийн “Хурдан” цэгийн байршилд газар дээр нь очиж хяналтыг хэрэгжүүлж, багийн төвийн албан хаагчдаас шаардлагатай сургалт, мэдээллээр хангаж байгаа эсэхийг судалгааг авч нэгтгэхэд “ХУРДАН” цэгийн үйлчилгээг үзүүлэхэд нэмэлт сургалт авч хөгжүүлэх шаардлага байна уу? гэсэн асуултад 14 албан хаагч буюу 46.7 хувь нь “Тийм” гэж хариулжээ.

Дээрхээс үзэхэд цаашид иргэд цахим үйлчилгээ авах нь нэмэгдэх хандлагатай байгаа тул өөрийн багийн төвийн байранд байрлах “Хурдан” цэгт цахим үйлчилгээ үзүүлж буй албан хаагчдыг шаардлагатай нэмэлт сургалтуудад хамруулах хэрэгцээтэй байна.

2.1.4 Төрийн байгууллагын албан хаагчдын 78.1 хувийг эмэгтэй албан хаагч эзэлж байна.

Аймгийн хэмжээнд 2016 онд төрийн албан хаагчдын 70.1 хувийг эмэгтэй албан хаагч эзэлж байгаа бол 2023 онд 78.1 хувь болж өссөн үзүүлэлттэй байна.

Сүүлийн 3 жилийн дунджаар нийт төрийн албан хаагчдын 87.3 хувийг төрийн үйлчилгээний, 10 хувийг төрийн захиргааны, 2.7 хувийг төрийн тусгай болон улс төрийн албан хаагчид эзэлж байна.

Аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн 144.2-т “Өмчийн төрөл, хэлбэрээс үл хамаарч 25 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нийт ажлын байрныхаа дөрвөн хувиас доошгүй орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулна” гэж заасны дагуу хяналт тавин ажиллажээ.

Тайлант оны байдлаар Дархан-Уул аймгийн 25 ба түүнээс дээш ажилтантай 61 төрийн байгууллагад хуулийн дагуу 142 хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулахаас 150 хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллаж байна.

2.1.5 Төрийн үйлчилгээг цахим технологид шилжүүлснээр үйлчилгээний шат дамжлага буурсан байна.

Монгол Улс төрийн үйлчилгээг цахимжуулах, цахим засаглалыг хөгжүүлэх зорилгоор Засгийн газар 2018 оны 259 дүгээр тогтоолоор 46 төрийн байгууллагын 478 төрийн үйлчилгээ, 2023 оны 100 дугаар тогтоолоор 56 байгууллагын 785 төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх жагсаалтыг нэмж баталжээ.

Засгийн газраас 2018 онд e-mongolia төслийг хэрэгжүүлснээр төрийн үйлчилгээг цахим технологид шилжүүлэх, олон шат дамжлагыг багасгах, иргэн, хуулийн этгээдэд

хүндрэл чирэгдэлгүй үйлчилгээг үзүүлэх 1,263 төрлийн цахим үйлчилгээг бий болгоод байна.

Төрийн үйлчилгээ цахимд шилжсэнээр үйлчилгээний шат дамжлага, баримтын бүрдүүлэлт шийдвэрлэх хоногийн хугацаа буурсан байна. Цахимаар үйлчлүүлэгч иргэд давхардсан тоогоор 2021-2024 онд 530.7 мянга буюу өмнөх оноос 522.4 мянгаар, цахим үйлчилгээний төрөл 307-оор нэмэгдсэн байна

2.3.1 Орон нутагт төрийн үйлчилгээг хүргэх цэг нэмэгдсэн байна

Төрийн үйлчилгээг түргэн шуурхай, хүртээмжийг нэмэгдүүлэхээр Засгийн газраас 2018 онд “Цахим засаглалыг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг баталж, e-mongolia төслийн хүрээнд “ХУРДАН” системийг нэвтрүүлж эхэлсэн байна.

Дархан-Уул аймагт 2023 оны 5 дугаар сард “Төрийн цахим үйлчилгээний хэлтэс”-ийг ажиллуулснаар 6.4 мянган иргэнд, “Дархан монгол шуудан”, багийн 7 төв, 3 суманд нийт 11 үйлчилгээний цэг шинээр байгуулснаар 2024 оны 9 дүгээр сарын байдлаар цахим үйлчилгээ авсан иргэдийн тоо 4.6 дахин нэмэгдэж 29.9 мянгад хүрсэн байна.

2.3.2 Төрийн байгууллагуудын хороонд мэдээлэл солилцох ERP программд аймгийн 124 байгууллага бүртгэлтэй ч ашиглалт хангалтгүй байна.

“Дархан цахим” хөтөлбөрийн хүрээнд, төрийн байгууллагуудын хооронд мэдээлэл солилцох “Able” программыг 2014 онд нэвтрүүлжээ. Уг программд Төрийн цахим үйлчилгээний газраас 2024 онд сайжруулалт хийгдэн, “ERP” системийг ашиглах болсон байна. Одоогоор нийт 124 байгууллагын 3,636 хэрэглэгч бүртгэлтэйгээс 832 хэрэглэгч идэвхтэй байна.

Төрийн үйлчилгээний ил тод нээлттэй үйл ажиллагааны тайлан, мэдээг холбогдох байгууллагууд өөрсдийн вэб сайтын “үйл ажиллагааны ил тод байдал”-ын буланд тайлагнаж, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралт 9, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар баталсан хавсралт 7 маягтын дагуу байгууллагын гүйцэтгэлийн тайланг бэлтгэн гаргаж дээд шатны байгууллагаар үнэлүүлж ирсэн байна.

Аудитаар 726.9 мянган төгрөгийн алдаа зөрчилд төлбөрийн акт тогтоож, цаашид үйл ажиллагаанд мөрдөж ажиллах 12 зөвлөмж, ТА3-д 3 санал өгсөн.